



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/135

Баянбулаг

Бүтэц, орон тоо батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 259 дугаар тогтоол, Засаг даргын зөвлөлийн 2024 оны 06 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн "Биеийн тамир, спортын газар"-ын бүтэц, орон тоог хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Баталсан захирамжийг мөрдөж ажиллахыг Биеийн тамир, спортын газрын дарга (Ж.Уранчимэг)-т үүрэг болгосугай.
3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/425 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын Тамганы
 Ах дугаар сарын 05 ны өдрийн 15 дугаар
 захирамжийн хавсралт

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
 БҮТЭЦ, ОРОН ТОО** ГЗЛ0042

№	Албан тушаал	Ангилал, зэрэглэл	Орон тоо
ЗАХИРГАА, АЖ АХУЙН ХЭЛТЭС-16			
1	Биеийн тамир, спортын газрын дарга	ТЗ-4	1
2	Тогтоол, шийдвэр тайлан мэдээ, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн	ТЗ-8	1
3	Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-9	1
4	Мэдээллийн цахим сан, статистик хариуцсан мэргэжилтэн	ТЗ-9	1
5	Нягтлан бодогч	ТҮ-8	1
6	Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан	ТҮ-5	1
7	Нярав, заал зохион байгуулагч	ТҮ-4	1
8	Сантехникч, цахилгаанчин	ТҮ-3	1
9	Харуул	ТҮ-1	4
10	Үйлчлэгч	ТҮ-1	4
БИЕИЙН ТАМИРЫН ХЭЛТЭС-4			
1	Биеийн тамирын хэлтсийн дарга (Биеийн тамирын бодлогын хэрэгжилт)	ТЗ-6	1
2	Бие бялдрын сорил, чийрэгжилт хариуцсан арга зүйч	ТҮСБ-4	1
3	Хүүхэд, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй хүний биеийн тамирын асуудал хариуцсан арга зүйч	ТҮСБ-4	1
4	Албан байгууллага, аж ахуйн нэгж, сумдын биеийн тамирын бодлого хэрэгжилт, арга зүйчийн асуудал хариуцсан арга зүйч	ТҮСБ-4	1
СПОРТЫН ХЭЛТЭС-4			
1	Спортын хэлтсийн дарга (Спортын сургалт, дасгалжуулалт, төлөвлөлт)	ТЗ-6	1
2	Спортын тэмцээн наадам, шагнал урамшуулал хариуцсан арга зүйч	ТҮСБ-4	1
3	Өсвөрийн шигшээ баг, хүүхдийн спорт хариуцсан арга зүйч	ТҮСБ-4	1
4	Спортын холбоод, цол зэрэг хариуцсан арга зүйч	ТҮСБ-4	1
НИЙТ			24